

Дэлхий даяарх анхдагчид

Америкийн Самоа

“Бурхан тийм гэж хэлсэн”

Лева ‘аиа Левао эрүүл мэндийн ноцтой асуудалтай амьдарч байв. 2015 онд түүний нүдэн дээр хатиг гарчээ. Номлогчид түүнд санваарын адислал өгсний дараа хатиг нь эдгэсэн юм. Тэд түүнтэй хамт Мормоны Номыг уншиж эхлэв.

Арлын жижиг нийгмийн зарим хүн Леваог шинэ шашныг анхааран авч үзэж байгааг хараад, сэтгэл дундуур байлаа. Тэд түүний хичээл зүтгэлийг шоолж, доромжлов. Гэсэн хэдий ч тэр тууштай байж, удалгүй баптисм хүртжээ. Нөхөр Туи болон гурван хүүхэд нь удалгүй түүнийг дагаж итгэсэн бөгөөд Левао дараа нь салбартаа Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчөөр үйлчлэв. Түүний өөрийгөө бусдын төлөө зориулах үлгэр жишээнээс урам зориг авсан бусад хүн түүнийг Олосега дахь Сүмийн зүрх гэж нэрлэжээ.

Өмнөд Солонгос

“Би дахиж хэзээ ч жинхэнээсээ даарахгүй”

Чэй Донг Сулл бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс цуглааныхаа гишүүдийг хамгаалах үүрэгтэй гэж боддог байсан пресбитериан шашны санваартан байв. Гэсэн хэдий ч тэрээр номлогчидтой уулзаж эхлэн, өөрийг нь зовоож байсан сургаалын асуудлуудыг тодорхой болгож байв. Тэрээр өөрийнх нь шинэ итгэл үнэмшил түүнээс ажил мэргэжлээ өөрчлөхийг шаардаж, тухайн үед Солонгосын пресбитериан сүмийн дарга байсан аавтайгаа харилцах харилцаанд нь аюул учруулах болно гэдгийг мэдэж байсан.

Донг Сулл Хан мөрөнд баптисм хүртэхийг сонгосон юм. “Би баптисм хүртэхдээ аль болох Есүс Христтэй адил туршлагатай байхыг хүссэн” гэж тэр тайлбарлав. 1981 оны 9-р сарын 5-ны манан будан татсан өглөө Хан мөрний ус хүйтэн байсан ч тэрээр уснаас гарч ирчхээд, дотроо мэдэрсэн дулааныг дүрслэн ийн ярьжээ. “Одоо би Бурханы жинхэнэ Сүмд харьяалагддаг боллоо. Би дахиж хэзээ ч жинхэнээсээ даарахгүй” гэж тэр хэлэв. Хоёр долоо хоногийн дараа түүний эхнэр, хоёр хүү баптисм хүртсэн ба энэ удаад баптисм дулаахан цуглааны байранд болов. Сүмд нэгдэх нь Донг Суллын болон түүний гэр бүлийн амьдралыг амар хялбар болгоогүй ч шинэ адислалуудыг авах боломжтой болгосон юм. “Баптисм хүртсэний дараа хавчлага, зовлон зүдгүүрийг үгээр хэлэмгүй. Бид [Сүмд нэгдэх] үйл явцын дунд ихийг алдсан ч мөрөөдөж байснаасаа ч илүү их зүйлийг олж авч чадсан” гэж Донг Сулл хэлжээ.

Кот-д’Ивуар

“Амьдрал, аз жаргалын хаалга”

Эцэг эх нь хоёулаа нас барахад Лиди Зэбо Бахи гэртээ үлдсэн сүүлчийн хүүхэд болов. Энэ аймшигт үхэл хагацал түүнийг ноцтой сэтгэлийн хямралд хүргэжээ. Ач дүү Фаэт Надэгэ нь түүнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмтэй танилцуулав.

Анх удаа сүмд явахдаа Лиди Халамжийн нийгэмлэгийн болон Залуу эмэгтэйчүүдийн байгууллагын эгч нараас маш их хайр мэдэрчээ. Тэрээр сэтгэлийн хямралд орсон үедээ ном уншихаа болиод байсан ч Мормоны Номыг судалж байхдаа дахин анхаарлаа төвлөрүүлж чадсан аж. Тэр 1995 оны 11-р сард баптисм хүртсэн.

Баптисм хүртээд удаагүй байхдаа тэрээр Халамжийн нийгэмлэгт болон Залуу эмэгтэйчүүдийн байгууллагад үйлчилж, өөрт нь үзүүлсэн хайрыг эргүүлэн өгөх боломж түүнд олдсон юм. Мөн тэрээр салбарын номлогчоор үйлчилж, өөрийнхөө саяхан олж мэдсэн нөхөрлөл, амар амгаланг олж мэдэхэд бусдыг урьж байв. Лиди: “Эдгээр бүх дуудлага намайг хүчирхэгжүүлж, сүнслэг болоод оюун санааны байдлын хувьд ахиц дэвшил гаргахад минь тусалсан” гэж хэлжээ.

Лиди Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Киншаса номлолд үйлчилсэн хамгийн анхны номлогч эгч нарын нэг болсон юм.